



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 21

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын есдүгээр хуралдаанаас ТОГТООХ НЬ:

Нэг. Хот тохижуулах газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 4,312,500 /дөрвөн сая гурван зуун арван хоёр мянга таван зуу/ төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

Хоёр. Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

Гурав. Хот тохижуулах газрын дарга (Д.Очбадрах)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1 Эд хөрөнгийг худалдах хүртэлх хугацаанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 8.4 дэх заалтыг хэрэгжүүлэх;

3.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, худалдсан автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлэх;

3.3 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Дөрөв. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



СОД ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн
... тогтоолын хавсралт



Хот тохижуулах газрын дуудлагаар худалдах тээврийн хэрэгслийн жагсаалт

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглагдсан орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сери	Дугаар						
1	Ачааны	KIA Fronter	ДУА	53-65	2001	2009	312,500	312,500	0	500,000 /таван зуун мянга/ төгрөг
2	Тусгай зориулалтын	DONGFENG	ДУА	76-44	2007	2007	4,000,000	2,777,777.75	1,222,222.25	500,000 /таван зуун мянга/ төгрөг
Нийт хөрөнгийн дүн							4,312,500 /дөрвөн сая гурван зуун арван хоёр мянга таван зуун төгрөг/	2,777,777.75 /хоёр сая долоон зуун далан долоон мянга долоон зуун далан долоон төгрөг далан таван мөнгө/	1,222,222.25 /нэг сая хоёр зуун хорин хоёр мянга хоёр зуун хорин хоёр төгрөг хорин таван мөнгө/	